

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/286/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 261663 Цахим хаяг: Tsogbayara@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Ариунжаргал Утас: 261740 Цахим хаяг: Ariunjargalb@audit.gov.mn Аудитор: Г.Өсөхжаргал Утас: 261740 Цахим хаяг: Usukhjargalg@audit.gov.mn Аудитор: Д.Номингуа Утас: 261740 Цахим хаяг: Nominguad@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт	16
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	16
3.5.3 Нэмэлт төсөв	18
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	18
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	24
4.5.1 Завсрын аудитын талаар	24
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	25
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	26
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	32

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ҮАГ	Үндэсний аудитын газар
САГ	Санхүүгийн аудитын газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХГБХХЕГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ,
ХАМГААЛЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАЯРСАЙХАН ТАНАА

2026.02.25 № 06/365
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,453,071.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

1. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын үйл ажиллагааг цахим технологийн тусламжтай иргэн бүрт хүртээмжтэй хүргэх ажлын хүрээнд "Гэр бүлийн виртуал зөвлөх" үйлчилгээний төлбөрт нийт 535,275.0 мянган төгрөгөөс барьцаа хөрөнгийг тооцоогүй санхүүжилтийг бүрэн олгосон, уг зөвлөх үйлчилгээ нь бүрэн ашиглагдаагүй;
2. Анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтын шаардлага хангаагүй нийт 180,971.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн;
3. Тайлант онд худалдан авсан нийт 168,367.0 мянган төгрөгийн материалыг бараа материалын дансанд бүртгээгүй шууд зардалд зарцуулсан зэрэг зөрчлүүд илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 16.5.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах

тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын “ангилал”, “нийцсэн ба зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нэмэлт санхүүжилтийн дансанд Нэгдсэн Үндэсний Байгууллагын хүүхдийн сангаас 124,983.4 мянган төгрөгийн мөнгөн хандив хүлээн авч, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 63,057.1 мянган төгрөгийн нэмэлт орлого, нийт 188,040.5 мянган төгрөгийн орлого төвлөрч, гүйцэтгэлээр 101,987.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 86,052.7 мянган төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлжээ.

Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдах хувьсах зардлын санхүүжилтэд 3,635,539.9 мянган төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 2,699,576.9 мянган төгрөгийг харьяа дүүрэг, орон нутгийн хүүхэд гэр бүл, хөгжил хамгааллын газруудад олгосон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 196 дугаар тогтоолоор Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын чиг үүргийг төрийн захиргааны болон харьяа дүүргийн холбогдох байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэнтэй холбоотой тус газрын урсгал төсвөөс хувийн 5 асрамж, халамжийн төвүүдэд хүүхдийн хоолны хувьсах зардалд зориулан 197,034.1 мянган төгрөгийг зарцуулсан.

Бусад асуудал

Харьяа 21 аймаг, 9 дүүргийн газар, хэлтсийн дэргэдэх гэр бүлд зөвлөгөө өгөх 31 төвөөр дамжуулан танхимаар 97,101 иргэнд нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөөг үзүүлснээс 55,233 насанд хүрэгч, 39,706 хүүхэд, 16,335 өрх хамрагдсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	131,459,390.72	654,292,243.06
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	40,716,422.00	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	40,716,422.00	-
31210	Төгрөг	40,716,422.00	-
31211	Төрийн сангийн харилцах	40,716,422.00	-
33	АВЛАГА	4,270,000.00	62,849,812.06
33300	Татаас, санхүүжилтийн авлага	4,270,000.00	48,942,456.00
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	-	13,907,356.06
34	УРЬДЧИЛГАА	22,401,370.72	310,950,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	22,401,370.72	310,950,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	64,071,598.00	280,492,431.00
35400	Хангамжийн материал	64,071,598.00	280,492,431.00
35410	Бичиг хэргийн материал	8,876,375.00	2,448,350.00
35420	Аж ахуйн материал	5,698,202.00	229,850,145.00
35440	Түлш, шатах тослох материал	316,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	49,181,021.00	48,193,936.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,247,716,577.60	2,280,251,107.83
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,247,716,577.60	2,280,251,107.83
39200	Биет хөрөнгө	1,228,923,901.92	1,411,752,875.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,296,194,926.88	2,296,194,926.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,381,754,854.76)	(1,419,791,436.92)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	119,500,000.00	140,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(77,901,041.87)	(96,776,041.91)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,284,691,610.00	1,637,729,910.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,110,724,688.43)	(1,206,899,479.67)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	104,387,204.00	104,387,204.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,086,648.45)	(51,466,762.26)
39214	Бусад үндсэн хөрөнгө	63,100,255.00	63,100,255.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(52,482,860.45)	(55,225,699.97)
39300	Биет бус хөрөнгө	18,792,675.68	868,498,232.68
39301	Програм хангамж	284,048,000.00	436,218,529.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(282,858,000.00)	(1,340,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	160,434,620.00	576,451,648.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(142,831,944.32)	(142,831,944.32)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,379,175,968.32	2,934,543,350.89
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,321,991.00	10,459,700.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,321,991.00	10,459,700.00
41300	Өглөг	4,321,991.00	10,459,700.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	51,991.00	-
41360	Бусад өглөг	4,270,000.00	10,459,700.00
41361	Байгууллагад төлөх өглөг	4,270,000.00	10,459,700.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,374,853,977.32	2,924,083,650.89
51	Засгийн газрын хувь оролцоо	1,374,853,977.32	2,924,083,650.89
51100	Засгийн газрын оруулсан капитал	511,123,914.11	511,123,914.11
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	511,123,914.11	511,123,914.11
51200	Хуримтлагдсан үр дүн	(32,755,765.35)	1,516,473,908.22
51210	Өмнөх үеийн үр дүн	138,095,918.54	(32,755,765.35)
51220	Тайлант үеийн үр дүн	(170,851,683.89)	1,549,229,673.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	896,485,828.56	896,485,828.56
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,379,175,968.32	2,934,543,350.89

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,722,637,226.99	9,960,263,185.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	115,572,044.00	9,960,263,185.00
120	Нийтлэг татварын бус орлого	115,572,044.00	779,149,528.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	115,572,044.00	779,149,528.00
122	Тусламжийн орлого	-	9,181,113,657.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	9,181,113,657.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	8,993,073,086.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	8,993,073,086.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	188,040,571.00
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	124,983,440.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	63,057,131.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,606,885,182.99	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,259,491,333.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,259,491,333.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	347,393,849.99	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	298,258,150.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,582,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	42,553,699.99	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,893,488,910.88	8,411,033,511.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,893,488,910.88	8,411,033,511.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,076,816,882.17	7,495,734,492.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,162,212,362.64	1,390,268,595.80
210101	Үндсэн цалин	792,209,369.26	829,963,826.16
210102	Нэмэгдэл	177,519,383.38	248,129,026.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	145,396,000.00	244,735,038.52
210104	Урамшуулал	47,087,610.00	67,440,704.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	146,084,706.49	176,649,595.36
210201	Тэтгэврийн даатгал	110,710,030.36	122,094,439.56
210202	Тэтгэмжийн даатгал	9,478,885.05	15,170,967.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,610,509.89	4,370,394.96
210204	Ажилгүйдлийн даатгал	4,241,074.45	7,296,084.53
210205	Эрүүл мэндийн даатгал	17,044,206.74	27,717,708.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,457,073.81	39,116,201.78
210301	Гэрэл, цахилгаан	17,999,097.94	18,353,005.16
210302	Түлш, халаалт	28,190,001.24	16,225,485.28
210303	Цэвэр, бохир ус	6,827,974.63	4,537,711.34
210304	Байрны түрээс	13,440,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	311,489,892.01	464,509,310.10
210401	Бичиг хэрэг	167,662,683.00	160,216,599.00
210402	Тээвэр, шатахуун	53,876,873.00	28,772,030.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,371,877.01	10,439,365.00
210404	Ном, хэвлэл	7,000,000.00	27,630,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	756,000.00	1,027,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,817,395.00	236,424,316.10
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	54,005,064.00	-
2105	Нормативт зардал	32,421,300.00	199,845,552.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	1,250,000.00

Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	32,421,300.00	198,595,552.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,352,000.00	15,933,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,900,000.00	-
210604	Урсгал засвар	6,452,000.00	15,933,000.00
2107	Томилолт, зочны зардал	73,469,450.00	34,094,900.00
210702	Дотоод албан томилолт	73,469,450.00	34,094,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,833,191,120.80	4,291,616,154.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,749,758,731.80	4,213,392,415.50
210803	Даатгалын үйлчилгээ	171,720.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	171,300.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90,778.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	82,802,910.00	77,865,518.46
210807	Газрын төлбөр	195,681.00	358,221.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	443,138,976.42	883,701,182.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,913,919.81	86,142,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,500,000.00	605,159,656.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	424,725,056.61	192,399,326.77
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	816,672,028.71	915,299,018.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,984,000.00	147,136,119.98
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	54,468,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	85,227,119.98
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,984,000.00	7,441,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	791,688,028.71	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	749,134,274.72	-
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	42,553,753.99	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	768,162,898.68
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	768,162,898.68
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(170,851,683.89)	1,549,229,673.57
VI	НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(170,851,683.89)	1,549,229,673.57

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	7,654,560,916.99	9,181,113,657.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,150,734.00	9,181,113,657.00
120	Нийтлэг татварын бус орлого	44,150,734.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	44,150,734.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	44,150,734.00	-
122	Тусламжийн орлого	-	9,181,113,657.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	9,181,113,657.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	8,993,073,086.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	8,993,073,086.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	188,040,571.00
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	188,040,571.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,610,410,182.99	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,259,491,333.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,259,491,333.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	350,918,849.99	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	298,258,150.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,582,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	46,078,699.99	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	7,563,313,322.99	8,777,257,750.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,563,313,322.99	8,777,257,750.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,739,636,264.28	7,807,076,275.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,202,761,010.38	1,401,270,797.83
210101	Үндсэн цалин	642,526,408.81	825,239,962.84
210102	Нэмэгдэл	290,949,810.34	240,218,188.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	184,169,156.23	268,371,942.16
210104	Урамшуулал	85,115,635.00	67,440,704.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	145,364,801.75	179,606,740.39
210201	Тэтгэврийн даатгал	101,473,277.07	121,546,177.66
210202	Тэтгэмжийн даатгал	11,883,501.29	13,208,491.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,789,216.75	12,180,733.10
210204	Ажилгүйдлийн даатгал	5,299,079.51	6,438,213.53
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	20,919,727.13	26,233,124.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,797,509.31	39,116,201.78
210301	Гэрэл, цахилгаан	17,999,097.94	18,353,005.16
210302	Түлш, халаалт	32,530,436.74	16,225,485.28
210303	Цэвэр, бохир ус	6,827,974.63	4,537,711.34
210304	Байрны түрээс	13,440,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	51,119,742.01	61,708,766.00
210401	Бичиг хэрэг	16,272,600.00	9,954,522.00
210402	Тээвэр, шатахуун	9,866,700.00	2,435,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,717,827.01	10,543,315.00
210404	Ном, хэвлэл	7,000,000.00	27,630,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,512,000.00	1,585,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,750,615.00	9,560,429.00
2105	Нормативт зардал	36,476,346.00	198,014,082.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	1,250,000.00
210502	Хоол, хүнс	35,996,346.00	194,754,082.00

Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	480,000.00	2,010,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,619,564.50	17,309,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	494,200.00
210604	Урсгал засвар	16,619,564.50	16,815,000.00
2107	Томилолт, зочны зардал	73,990,050.00	37,626,950.00
210701	Гадаад албан томилолт	-	16,501,400.00
210702	Дотоод албан томилолт	73,990,050.00	21,125,550.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,106,506,800.33	4,987,592,283.34
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,992,833,040.61	4,930,605,364.60
210803	Даатгалын үйлчилгээ	171,720.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	171,300.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90,778.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	113,044,280.72	56,628,697.74
210807	Газрын төлбөр	195,681.00	358,221.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,000,440.00	884,831,254.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,716,500.00	116,095,006.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,283,940.00	768,736,248.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	823,677,068.71	970,181,474.66
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	791,158,538.68
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	791,158,538.68
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	791,158,538.68
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	705,105,767.68
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\	-	63,057,131.00
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	22,955,640.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,719,040.00	153,076,119.98
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	54,468,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	85,227,119.98
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,719,040.00	13,381,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	795,958,028.71	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	753,404,274.72	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	42,553,753.99	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	25,946,816.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	25,946,816.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	91,247,584.00	403,855,907.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	55,551,890.00	444,572,329.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	55,551,890.00	444,572,329.00
2200	Дотоод эх үүсвэрээр	55,551,890.00	444,572,329.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	55,551,890.00	444,572,329.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(55,551,890.00)	(444,572,329.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	35,695,694.00	(40,716,422.00)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,020,728.00	40,716,422.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	40,716,422.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	511,123,914.11	896,485,828.56	138,095,918.54	1,545,705,661.21
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	511,123,914.11	896,485,828.56	138,095,918.54	1,545,705,661.21
Тайлант үеийн үр дүн	-	-	(170,851,683.89)	(170,851,683.89)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	511,123,914.11	896,485,828.56	(32,755,765.35)	1,374,853,977.32
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	511,123,914.11	896,485,828.56	(32,755,765.35)	1,374,853,977.32
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	511,123,914.11	896,485,828.56	(32,755,765.35)	1,374,853,977.32
Тайлант үеийн үр дүн	-	-	1,549,229,673.57	1,549,229,673.57
2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	511,123,914.11	896,485,828.56	1,516,473,908.22	2,924,083,650.89

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	10,050,561,700.00	8,287,967,318.32	1,762,594,381.68	82.5
Татварын бус орлого	10,050,561,700.00	8,287,967,318.32	1,762,594,381.68	82.5
Тусламжийн орлого	10,050,561,700.00	8,287,967,318.32	1,762,594,381.68	82.5
Төсвөөс санхүүжих	10,050,561,700.00	8,287,967,318.32	1,762,594,381.68	82.5
II. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,050,561,700.00	8,287,967,318.32	1,762,594,381.68	82.5
УРСГАЛ ЗАРДАЛ	10,050,561,700.00	8,993,073,086.00	1,057,488,614.00	89.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,878,932,900.00	8,147,272,198.34	1,731,660,701.66	82.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,529,346,500.00	1,401,270,797.83	128,075,702.17	91.6
Үндсэн цалин	819,069,400.00	825,239,962.84	(6,170,562.84)	100.8
Нэмэгдэл	304,308,600.00	240,218,188.51	64,090,411.49	78.9
Унаа хоолны хөнгөлөлт	280,168,500.00	268,371,942.16	11,796,557.84	95.8
Урамшуулал	125,800,000.00	67,440,704.32	58,359,295.68	53.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	190,260,700.00	179,606,740.39	10,653,959.61	94.4
Тэтгэврийн даатгал	127,305,700.00	121,546,177.66	5,759,522.34	95.5
Тэтгэмжийн даатгал	14,606,400.00	13,208,491.75	1,397,908.25	90.4
ҮОМШӨ-ний даатгал	11,869,600.00	12,180,733.10	(311,133.10)	102.6
Ажилгүйдлийн даатгал	7,325,100.00	6,438,213.53	886,886.47	87.9
Эрүүл мэндийн даатгал	29,153,900.00	26,233,124.35	2,920,775.65	90.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,287,200.00	39,116,201.78	51,170,998.22	43.3
Гэрэл, цахилгаан	55,766,600.00	18,353,005.16	37,413,594.84	32.9
Түлш, халаалт	26,746,300.00	16,225,485.28	10,520,814.72	60.7
Цэвэр, бохир ус	7,774,300.00	4,537,711.34	3,236,588.66	58.4
Хангамж, бараа материалын зардал	84,468,300.00	61,708,766.00	22,759,534.00	73.1
Бичиг хэрэг	14,869,100.00	9,954,522.00	4,914,578.00	66.9
Тээвэр, шатахуун	12,399,700.00	2,435,000.00	9,964,700.00	19.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,096,600.00	10,543,315.00	2,553,285.00	80.5
Ном, хэвлэл	30,125,400.00	27,630,000.00	2,495,400.00	91.7

Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хог хаягдал зайлуулах, хортон мэргэчдийн устгал, ариутгал	3,423,700.00	1,585,500.00	1,838,200.00	46.3
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,553,800.00	9,560,429.00	993,371.00	90.6
Нормативт зардал	344,593,100.00	198,014,082.00	146,579,018.00	57.5
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,488,600.00	1,250,000.00	3,238,600.00	27.8
Хоол, хүнс	325,484,200.00	194,754,082.00	130,730,118.00	59.8
Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,620,300.00	2,010,000.00	12,610,300.00	13.7
Эд хогшил, урсгал засварын зардал	46,173,500.00	16,815,000.00	29,358,500.00	36.4
Багаж, техник, хэрэгсэл	11,880,000.00	-	11,880,000.00	-
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	430,000.00	-	430,000.00	-
Урсгал засвар	33,863,500.00	16,815,000.00	17,048,500.00	49.7
Томилолт, зочны зардал	24,850,000.00	14,804,150.00	10,045,850.00	59.6
Дотоод албан томилолт	24,850,000.00	14,804,150.00	10,045,850.00	59.6
Нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,564,567,400.00	5,246,023,812.34	1,318,543,587.66	79.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,309,751,600.00	5,073,800,364.60	1,235,951,235.40	80.4
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100.00	-	100.00	-
Даатгалын үйлчилгээ	311,900.00	-	311,900.00	-
Тээврийн хэрэгслийн татвар	387,000.00	-	387,000.00	-
Тээврийн хэрэгслийн оношлогоо	229,300.00	-	229,300.00	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	251,880,400.00	171,865,226.74	80,015,173.26	68.2
Газрын төлбөр	2,007,100.00	358,221.00	1,648,879.00	17.8
Бараа үйлчилгээний бусад зардал	1,004,386,200.00	989,912,648.00	14,473,552.00	98.6
Бараа үйлчилгээний бусад зардал	117,206,300.00	113,706,400.00	3,499,900.00	97.0
Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	887,179,900.00	876,206,248.00	10,973,652.00	98.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	171,628,900.00	140,695,119.89	30,933,680.02	82.0
Бусад урсгал шилжүүлэг	171,628,900.00	140,695,119.98	30,933,780.02	82.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	83,550,000.00	54,468,000.00	29,082,000.00	65.2
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	87,078,800.00	85,227,119.98	1,851,680.02	97.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	40,716,422.00	(40,716,422.00)	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	-	100.0
Төсвийн байгууллага	2	2	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	65	51	14	78.5
Удирдах ажилтан	3	3	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	62	48	14	77.4
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	61	42	19	68.9
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	52	35	17	67.3
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	7	2	77.8
НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	2	2	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	188,040,571.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	188,040,571.00
122	Тусламжийн орлого	188,040,571.00
1221	Хандив тусламж /дотоод/	188,040,571.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	188,040,571.00
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	188,040,571.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	101,987,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	101,987,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	101,987,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,360,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,360,000.00
2107	Томилолт, зочны зардал	22,822,800.00
210701	Гадаад албан томилолт	16,501,400.00
210702	Дотоод албан томилолт	6,321,400.00
2108	Нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	71,805,000.00
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	71,805,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	86,052,711.00
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(86,052,711.00)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(86,052,711.00)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Тогтвортой, аз жаргалтай, ирээдүйд итгэлтэй хүүхэд, гэр бүлийг төлөвшүүлэх, хөгжүүлэх, тэдний эрхийг хамгаалахад оршино” гэж тодорхойлсон байна.

“Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээрх хууль, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, гэр бүлийн боловсролыг дэмжих, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний нэр төрөл, чанарыг дээшлүүлэх, төрийн байгууллага, орон нутгийн нэгж, салбар байгууллагыг мэргэжил, арга зүй, удирдлагаар хангах” гэсэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар нь үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

- Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг хүний эрхэд суурилсан хандлага, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэрэгцээнд нийцүүлж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;
- Нотолгоонд суурилсан төлөвлөлтийг хэрэгжүүлж, судалгаа шинжилгээ, дэвшилтэд технологи, инновацад тулгуурласан хүртээмжтэй үйлчилгээг нэвтрүүлэх;
- Гэр бүл төвтэй хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагыг хөгжүүлэх;
- Хүний нөөцийн ур чадварыг тогтмол дээшлүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, мэдээлэл технологийн хурдацтай хөгжилд нийцсэн чадварлаг бүтцийг хөгжүүлэх, салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- Чанар үр дүн, нотолгоонд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт, хяналтын үйл ажиллагааг сайжруулах.

Тайлант оны онцлог үйл явдлууд:

- Монгол Улсад Хүүхдийн байгууллага, хөдөлгөөн үүсэж, хөгжсөний 100 жилийн ой тайлант онд тохиож, Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 143 дугаар тогтоолын дагуу тэмдэглэн өнгөрүүлжээ;
- Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/214 дүгээр тушаалын дагуу “ОНЫ ОНЦЛОХ ХҮҮХЭД” шалгаруулах арга хэмжээг хүүхдийн хөгжих, нийгмийн амьдралд оролцох, гаргасан амжилт, ололтыг алдаршуулах, үлгэр дуурайлал болгох зорилгоор “Оны онцлох хүүхэд”-ийг шалгаруулж, шагнал гардуулах ёслолыг 33 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулж, шалгарсан 97 хүүхдийн шагналын зардалд 32,400.0 мянган төгрөгийг зарцуулсан;
- Нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөөг 21 аймаг, 9 дүүргийн газар, хэлтсийн дэргэдэх гэр бүлд зөвлөгөө өгөх 31 төв, танхимаар дамжуулан үзүүлж, тайлант онд 97,101 иргэн, үүнээс 55,233 насанд хүрэгч, 39,706 хүүхэд, 16,335 гэр бүлд зөвлөгөө өгч ажилласан;
- Гэр бүлийн боловсрол олгох 8 модуль 24 сэдвээр 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн хэмжээнд 671 “Сургагч багш”-ийг бэлтгэн 376,453 (давхардсан тоогоор) иргэнийг гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамруулсан.;
- Байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг эцэг эх, асран хамгаалагчийн хамт “Оролцоод хөгжье” зуслангийн тусгай ээлжид 21 аймаг, 9 дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг зуслангийн үйлчилгээнд хамруулан ажилласан;
- Нийслэлийн ХГБХХГ, Монголын үндэсний зуслангуудын холбоотой хамтран Хүүхдийн зуслангийн бүлгийн багш бэлтгэх 2 удаагийн сургалтад 138 иргэнийг хамруулан гэрчилгээ олгосон. Мөн Монголын зуслангуудын төлөөллийг оролцуулан Зуслангийн шинэчлэл сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж 165 иргэн, баталгаажуулалтын шинжээчийн эрх олгох сургалтад 2025 оны агентлаг, аймаг, дүүргийн 31 хүний хамруулсан;

- “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ, зардлын норматив”-ын дагуу хувьсах зардалд нийт 9 асрамж, халамжийн төвийн 234 хүүхдэд 887,748.1 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомж, дүрэм журмыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд голлон мөрдөх дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дахь заалт;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” 112 дугаар тушаал;
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгавар;
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгавар гаргасан;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудит, мониторингийн газар нь Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын “Дотоод аудитын 2025 оны төлөвлөгөө батлах тухай” А/08 дугаар тушаалын удирдамж боловсруулан байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хэрэгжүүлэн, илэрсэн алдаа зөрчилд зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн батлаагүй, 2018 онд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомжтой нийцээгүй, шинэчлэн баталж мөрдөх ажил хийгдээгүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,555,367.4 мянган төгрөгөөр буюу 2 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	40,716.4	-	(40,716.4)
Авлага	4,270.0	62,849.8	58,579.8
Урьдчилгаа	22,401.3	310,950.0	288,548.6
Бараа материал	64,071.6	280,492.4	216,420.8
Үндсэн хөрөнгө	1,247,716.6	2,280,251.1	1,032,534.5
Нийт хөрөнгө	1,379,175.9	2,934,543.3	1,555,367.4
Өглөг	4,322.0	10,459.7	6,137.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,374,853.9	2,924,083.6	1,549,229.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,379,175.9	2,934,543.3	1,555,367.4

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, засгийн газрын хувь оролцоо данснууд байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 40,716.4 мянган төгрөгөөр буурсан нь Ахмадын сангийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тайлант оны эцэст улсын төсөвт буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой;
- Авлагын дансны үлдэгдэл 62,849.8 мянган төгрөг болж, 58,579.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Ахмадын сангийн дансны үлдэгдэл 25,946.8 мянган төгрөг, нэмэлт дансны үлдэгдэл 22,995.6 мянган төгрөг нийт 48,942.4 мянган төгрөгийг татан төвлөрүүлснийг санхүүгийн тайланд татаас санхүүжилтийн авлагаар, НДШ-ийн 13,907.4 төгрөгийн авлагыг бүртгэсэнтэй холбоотой;
- Урьдчилгаа дансны үлдэгдэл 310,950.0 мянган төгрөг нь Аргун студио ХХК-иар хийлгэсэн “Гэр бүлийн вертуал зөвлөх” AR контент үйлчилгээний төлбөр бөгөөд 36 сарын хугацаанд хийж гүйцэтгэх тул урьдчилж гарсан зардлаар тайлагнасантай холбоотой;
- Бараа материалын дансны үлдэгдэл 280,492.4 мянган төгрөг болж, 216,420.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 997,000 өрхөд тараах ухаалаг стикер наалт бэлтгэснээс голлон нөлөөлжээ;
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 2,280,251.1 мянган төгрөг болж, 1,032,534.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тус газрын нэр дээр бүртгэлтэй 416,017.3 мянган төгрөгийн үнэтэй 3 газрыг үндсэн хөрөнгөд бүртгэж, 363,132.5 мянган төгрөгийн үнэ төлбөргүй шилжүүлэн авсан хөрөнгө, тайлант онд худалдан авсан 434,878.5 мянган төгрөгийн программ хангамж, 10,905.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмжөөр нэмэгдэж, 192,399.3 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг нэмж байгуулсантай тус тус холбоотой;
- Өглөг дансны үлдэгдэл 10,459.7 мянган төгрөг болж, 6,137.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний өр төлбөр үүссэнтэй холбоотой;

- Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 1,549,229.7 мянган төгрөг болж 1,516,473.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны санхүүгийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Программ хангамжийн талаарх судалгааны талаар: Тус газар нь 552,896.0 мянган төгрөгийн үнэ бүхий 5 программ хангамжийг байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байна. Үүнээс тайлант онд төсвийн хөрөнгөөр нийт 434,878.5 мянган төгрөгийн өртөг бүхий 2 программ хангамжийг худалдан авсан. Үүнд:

- ✓ Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын салбарын албан хаагчид, оролцогчдыг чадавхжуулах сургалтын нэгдсэн платформд 215,000.0 мянган төгрөг;
- ✓ Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын анхдагч өгөгдөлд суурилсан статистик мэдээллийн “Үр дүнгийн цахим самбар” 219,878.5 мянган төгрөгийн өртөгтэй дашбоард бэлтгүүлэхэд тус тус зарцуулсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны төсвийн төсөлд урсгал үйл ажиллагааны зардлыг 14,871,612.8 мянган төгрөгөөр, 14,871,612.8 мянган төгрөгөөр зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн урсгал үйл ажиллагааны зардлыг нийт 5,781,511.5 мянган төгрөгөөр бууруулж 9,090,101.3 мянган төгрөгөөр баталжээ. Тухайлбал: цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 4,104.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 513.1 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 2,637.5 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 120.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 5,107.6 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 4,850.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 5,762,037.8 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 31,475.8 мянган төгрөгөөр бууруулж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4,756.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 24,578.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийг 9,090,101.3 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант оны батлагдсан төсвийн үндсэн үйл ажиллагааны зардлыг 197,274.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 67,981.7 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 10,317.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 23,863.5 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 24,403.3.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 593,315.4 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийг 7,444.1 мянган төгрөгөөр бууруулж, бараа үйлчилгээний бусад зардлыг 866,672.8 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 32,453.7 мянган төгрөг, нормативт зардлыг 18,028.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, төсвийг 9,279,931.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2, 42 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчид Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны батлагдсан төсөвт 7 удаагийн хуваарийн өөрчлөлт хийх саналыг хүргүүлж, шийдвэрлүүлсэн байна. Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр, арга хэмжээг 10,050,561.7 мянган төгрөгөөр улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 10,050,561.7 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 8,287,967.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 8,287,967.3 мянган төгрөг буюу 82.5 хувь байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 128,075.7 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 10,653.9 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 51,171.0 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 22,759.5 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 146,579.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 29,358.5 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 10,045.8 мянган төгрөгөөр, нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 1,318,543.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 14,473.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулж, зарцуулаагүй 705,105.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/					
Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
72207	Хүүхдийн хөгжил, хамгаалал	10,050,561.7	8,287,967.3	1,762,594.4	82.5
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,384,186.6	2,089,327.9	294,858.7	87.6
80102	Туслах үйл ажиллагааны зардал	260,614.6	244,822.8	33,327.8	93.7
80231	Хүүхэд харах үйлчилгээ	3,626,321.6	2,686,811.4	939,510.2	77.4
80237	Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардал	644,449.5	297,675.9	346,773.6	100
80238	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	1,313,974.1	1,302,845.0	11,129.1	99.1
80240	Хүүхдийн хөгжил, оролцоо	1,525,911.5	1,525,788.0	123.5	99.9
80802	Ажил олгогчоос олгох	171,628.8	140,695.1	30,933.7	82.0
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	105,939.0	-	105,939.0	-

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч аудитын тайланд тусгалаа. Үүнд:

1. Байгууллагын орон тооны цомхотгол: “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 54 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгаж оновчтой болгох, төрийн үйлчилгээний цахимжилтыг эрчимжүүлэх, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-нд туссан багш, эмч нараас бусад төрийн албан хаагчийг орон тоог 9 хувиар бууруулах арга хэмжээг авсан. ГБХНХС-ын 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/164 дүгээр тушаалаар тус газрын бүтэц, орон тоог 58 байхаар батлагдаж, гүйцэтгэлээр 51 орон тоотой ажиллаж, 7 орон тоогоор дутуу ажилласан байна. Тайлант онд цалингийн зардалд 1,529,346.5 мянган төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 1,401,270.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.
2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар: Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын 2024 оны А/210 дугаар тушаалаар албан хаагчдын ажлын нэг өдрийн хоолны мөнгийг 32.0 мянган төгрөгөөр, унааны зардлыг 1.0 мянган төгрөгөөр олгохоор баталжээ. Тайлант онд унаа хоолны хөнгөлөлтийн зардалд нийт 227,395.9 мянган төгрөгийг батлагдаж, гүйцэтгэлээр 224,919.9 мянган төгрөгийг зарцуулжээ.
3. Гадаад томилолт, арга хэмжээний талаар: Гадаад арга хэмжээний болон томилолтын зардал батлагдаагүй байна. Харин тайлант онд 16,501.4 мянган төгрөгийг дотоод албан томилолтын зардлаас, 7,971.0 мянган төгрөгийг сургалт, дадлага, бэлтгэлийн зардлаас, 11,542.6 мянган төгрөгийг мэргэжлийн үйлчилгээний зардлаас эрх бүхий байгууллагын шийдвэрээр гадаад албан томилолтын зардалд зарцуулжээ.

4. Сургалт, семинарын талаар: Тайлант хугацаанд сургалт, дадлага, бэлтгэлийн зардалд 887,179.9 мянган төгрөгийг баталснаас гүйцэтгэлээр 876,206.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.
5. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай ажил, үйлчилгээний гэрээний талаар: Хүүхэд, хамгаалал, урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг нийтлэх, шторк, постер, богино хэмжээний видео бичлэгээр олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон цахим орчноор дамжуулан иргэдэд хүргэх ажлын хүрээнд 2025 онд нийт 16 хуулийн этгээдтэй гэрээ байгуулан ажиллаж 116.950.0 мянган төгрөгийг санхүүжүүлжээ.
6. Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал байхгүй болно.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Нэгдсэн Үндэсний Байгууллагын хүүхдийн сангаас 124,983.4 мянган төгрөгийн мөнгөн хандив хүлээн авч, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 63,057.1 мянган төгрөг нийт 188,040.5 мянган төгрөгийн орлого төвлөрч, гүйцэтгэлээр 101,987.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 86,052.7 мянган төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/06 дугаар тушаалаар 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 7 багц бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад нийт 431,158.2 мянган төгрөгийн төсвийг баталж, тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 2 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжсан байна.

Тус газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/211 дүгээр тушаалаар 10 багц бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад нийт 1,438,000.0 мянган төгрөгийн зарцуулахаар баталж, 32,477.8 мянган төгрөгийн 5 шууд худалдан авалт хийж, 1,438,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 худалдан авалтыг "Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем"-ээр зохион байгуулжээ. Үүнд:

1. Хүүхэд, гэр бүлийн хөгжил оролцоог дэмжих үйл ажиллагааны ажлын хүрээнд 938,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авалтыг нэг үүсвэрээс худалдан авах ажиллагааны аргыг хэрэглэн “Аргун студио” ХХК-тай “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын үйл ажиллагааг цахим технологийн тусламжтай иргэн бүрт хүртээмжтэй хүргэх” ажил гүйцэтгэх гэрээг 535,275.0 мянган төгрөгөөр байгуулж, 997,000 ширхэг гар утсанд татан суулгах QR бүхий, зурагтай наадаг стикерийн зардалд 224,325.0 мянган төгрөг, “Гэр бүлийн виртуал зөвлөх” үйлчилгээг 3 жилийн хугацаатай ашиглах зардалд 310,950.0 мянган төгрөгийг зарцуулсан;
2. “Сургалт, хөгжүүлэлтийн нэгдсэн тогтолцооны дашбоард бэлтгүүлэх” 250,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж хамгийн бага үнийн санал ирүүлсэн “Бид солишин” ХХК-тай гэрээ байгуулж, гүйцэтгэлээр нийт 215,000.0 мянган төгрөгийг олгосон;
3. “Хүүхэд, гэр бүлийн мэдээллийн сан үйлчилгээ” 130,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй үйлчилгээний худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж, шалгарсан Орон нутгийн хөгжлийн бодлого судлалын төв нийтэд

үйлчилдэг төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж, гүйцэтгэлээр нийт 107,470.0 мянган төгрөгийг олгосон;

4. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн индекс 120,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж, шалгарсан "Эйблсофт" ХХК-тай гэрээ байгуулж, гүйцэтгэлээр нийт 112,408.5 мянган төгрөгийг олгосон;
5. Салбарын статистик маягт боловсруулах 15,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авалт нь "Сургалт, хөгжүүлэлтийн нэгдсэн тогтолцооны дашбоард бэлтгүүлэх" тендерийн үйл ажиллагаатай давхацсан тул цуцалсан, Ти Жи Икс ХХК-иас бичиг хэргийн материал худалдан авах зардалд 5,646.4 мянган төгрөг, Наран март ХХК-иас бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс худалдан авах зардалд 4,350.2 мянган төгрөг, Юнивишн ХХК-иас шуудан холбоо, интернэтийн төлбөр худалдан авах зардалд 4,151.2 мянган төгрөг, Петровис ХХК-иас тээвэр шатахуун худалдан авах зардалд 3,270.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Тайлант онд төсвийн үйл ажиллагааны худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөө, жагсаалтад өөрчлөлт ороогүй, худалдан авалтыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу зохион байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой төсвийн зарцуулалт, зардлын эдийн засгийн ангилал, үндсэн хөрөнгийн бүртгэл зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Ариунжаргал, аудитор Г.Өсөхжаргал, аудитор Д.Номингуа нар гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүүхэд, гэр бүлийн, хөгжил хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/79 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнийг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн болох 7,893,488.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 118,402.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн төслийн саналаар хүргүүлсэн зарим зардлыг татаж баталсан, аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 10,742,000.1 мянган төгрөгийн 10 зөрчил илэрсэнд, 10,736,528.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлагыг хүргүүлж, 5,472.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгсөн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар нь Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2,031,758.2

мянган төгрөгийн 14 гүйлгээ, зарлагын 3,081,748.5 мянган төгрөгийн 110 гүйлгээг мэдээлээгүй, 3,246,491.6 мянган төгрөгийн орлогын 16 гүйлгээг, 2,307,167.4 мянган төгрөгийн зарлагын 198 гүйлгээг хугацаа хоцроож, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой нийт 81 шийдвэрийг мэдээллийг байршуулаагүй, 27 шийдвэрийг хугацаа хоцруулж байршуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах;" Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.3-т "тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;" 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн байршуулаагүй, хугацаа хоцроосон, давтан гаргасан, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны тухай хуулийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Өмнөх оны аудитаар "Хурдан морь уралдаанч хүүхдийн бүртгэлийн систем хөгжүүлэх" ажлыг 19,250.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлэхээр "Эйблсофт" ХХК-тай, "Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авч буй хүүхдүүдийн бүртгэлийн систем хөгжүүлэх ажлын даалгавар боловсруулах, зөвлөх, үйлчилгээ авах" ажлыг 19,400.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлэхээр "Дийг Ай Ти" ХХК-тай гэрээ байгуулсан ч тус газар нь систем хөгжүүлэгчийг сонгон шалгаруулаагүйгээс ажлын даалгаварт тусгасан систем хөгжүүлэлт нэвтрүүлэлтийн явцад хяналт тавих, хөгжүүлэгчээс хүлээн авах, захиалагчдад хүлээлгэн өгөх зэрэг ажлууд хийгдээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон" зөрчлийг арилгахаар хүргүүлсэн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-т "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна." 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний ажлын даалгаварт тусгагдсан ажлыг бүрэн гүйцэтгээгүй байхад хүлээж авсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

2. Өмнөх оны аудитаар "Гэртээ эрт харья" аяныг зохион байгуулахаар Нийслэлийн мэдээллийн төвтэй 19,500.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан урьдчилгаа санхүүжилт 13,650.0 мянган төгрөгийг олгосон боловч гэрээний хугацаа дууссан, хэрэгжилтийг бүрэн хангуулаагүй" албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6-д "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-т "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулах ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, Нийслэлийн мэдээллийн төвтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг бүрэн хангуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

3. Өмнөх оны аудитаар" нэр бүхий 15 ажилтанд нийт 11,212.4 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон" зөрчлийг нөхөн төлүүлэхээр тогтоосон төлбөрийн актыг барагдуулаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;" 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн актыг барагдуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

4. Байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэхдээ санхүүгийн тайлан бэлтгэх шаардлагыг хангаагүй, мэргэжлийн бус эрх зүйч мэргэжилтэй албан хаагчид хариуцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д "мэргэжлийн нягтлан бодогч" гэж их, дээд сургууль, коллежийг нягтлан бодогчийн мэргэжлээр бакалавр буюу түүнээс дээш зэргээр төгссөн хүнийг; 18 дугаар зүйлийн 18.3-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, санхүүгийн тайланг гаргаж, тайлагнах этгээд нь мэргэжлийн, эсхүл мэргэшсэн нягтлан бодогч байна." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлан болон нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.6, 18.3-т заасны дагуу мэргэжлийн эсхүл мэргэшсэн нягтлан бодогчоор хариуцуулан явуулж, мэргэжлийн бус албан хаагчаар тайлан гаргуулах нөхцөл байдлыг дахин давтагдуулахгүй байх зөвлөмжийг өгсөн.

5. Байгууллагын хүний нөөц тогтворгүй, тайлант онд нийт 51 албан хаагчаас 6 албан хаагч өөр байгууллагад шилжсэн, 21 албан хаагч ажлаас чөлөөлөгдсөн нь аудитын явцад илэрч буй алдаа зөрчилд тайлбар болон шаардлагатай тайлан гаргуулах, баримт материалтай бүрэн танилцахад хүндрэл учруулж байсан. Нийслэлийн хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газрыг татан буулгасантай холбоотой чөлөөлөгдсөн албан хаагчдаас 9 албан хаагч шүүхийн байгууллагад хандсан байгаа нь төрд учрах хохирлын хэмжээ, байгууллагын өглөг, авлага нэмэгдэх эрсдэлийг бий болгож байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйл "Төрийн албаны зарчим" -ийн 7.1.2-т "Мэргэшсэн, тогтвортой байх", 39 дүгээр зүйлийн 39.1.3-т "хуульд нийцээгүй шийдвэр гаргах;", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын даргын Албан тушаалын тодорхойлолтод заасан албан тушаалын зорилтын 5-д "Хүүхдийн эрх, хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын байгууллагыг мэргэшсэн хүний нөөцөөр бүрдүүлэх, чадавхыг бэхжүүлэх, хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлж, тайлагнах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, мэргэшсэн боловсон хүчнээр бүрдүүлж чадавхыг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх зөвлөмж өгсөн.

6. Байгууллагын санхүүгийн харилцах дансны гүйлгээг зардлын баримттай тулган баталгаажуулахад баримт материал эмх цэгцгүй, зардлын нотлох баримтыг бүрэн бүрдүүлж хавсаргаагүй, тушаал, шийдвэрийн хуулбар хувийг хавсаргасан, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой зардал гаргах зарим тушаалын хавсралт дахь мөнгөн дүнгийн нийлбэр алдаатай нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын хавсралт маягтуудын дагуу архивын хадгаламжийн нэгжийг бүрдүүлээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1 "албан хэрэг хөтлөлтийн явцад үүссэн хавтаст баримтыг зохион байгуулалтын нэгж, ажилтнаас бүрэн бүрдэлтэй хүлээн авах", 24 дүгээр зүйлийн 24.1 "байгууллагын архив тухайн байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж, архивын баримтыг анхан шатанд бүрдүүлж, энэ хуульд заасан хугацаагаар түр хадгална", 24.1.9-д "архивын баримтын хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт тавих." Хууль зүй дотоод хэргийн сайдын баталсан 2021 оны А/222 дугаар тушаалаар баталсан Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 5.1-д "Архивын хадгаламжийн нэгж нь тодорхой шинжээр ангилан төрөлжүүлж, биет байдлаараа тус тусдаа хадгалагдаж байгаа бүртгэлийн дугаар бүхий нэг буюу хэд хэдэн баримт байна." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн баримт материалын бүрдэл, үнэн зөвийг хангаж, архивын баримтыг эмх цэгцтэй бүрдүүлэн хадгалах зохион байгуулалтын тогтолцоог сайжруулж, бүх төрлийн зардлын баримтыг шаардлагын дагуу бүрэн баримтжуулах арга хэмжээг авах зөвлөмж өгсөн.

7. Тус байгууллагын 2018 онд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомжтой нийцээгүй, шинэчлэн баталж мөрдөх ажил хийгдээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын санхүү, төсвийн удирдлагын зарчим болон байгууллагын үйл ажиллагаанд нийцүүлэн шинэчлэн боловсруулж батлан хэрэгжүүлэх замаар санхүүгийн бүртгэл, тайлагналын үнэн зөв байдлыг хангаж ажиллах зөвлөмж өгсөн.

8. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй СБД-ийн 8 дугаар хорооны Н-1-0087, 12 тоот хаягт байрлах 1460800074 нэгж талбарын дугаартай 5,472.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 57 м.кв газрын газрын эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дууссан байна.

Энэ нь Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-т "газар дээрх үл хөдлөх хөрөнгө нь тухайн газрын бүрдэл хэсэг байх.", 27 дугаар зүйлийн 27.2-т "Газар эзэмших эрхийн гэрчилгээг зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгоно", 27.4-т "Хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээгүй аливаа этгээд газар эзэмшихийг хориглоно", 47 дугаар зүйлийн 47.1-д "Газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол уг газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгө өмчлөгч этгээдийн тэрхүү эд хөрөнгөө тухайн газар дээр ашиглах эрх дуусгавар болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Газар эзэмших эрхийн гэрчилгээг холбогдох байгууллагад хандан шинэчилж авах.

9. Төрийн аудитын байгууллагад 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэг "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна"-т заасны дагуу иж бүрэн ирүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54.5 дахь хэсэг "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна"-ийн 54.5.4-т "хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/, 54.5.5-д "нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэг "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна"-т заасны дагуу иж бүрэн ирүүлэх.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны III улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл хөтөлж, шалгагдагч байгууллагад танилцуулсан. Завсрын аудитаар нийт 3,382,383.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 2,107,081.0 мянган төгрөгийн 5 алдааг залруулах, 1,280,773.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах талаар 11 зөвлөмж өгсөн. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэж, хэрэгжилтийг үнэлэхэд дараах байдалтай байна. Үүнд: Завсрын аудитаар илэрсэн зөрчлийг арилгаагүй асуудалд аудитын тайланд тусгасан.

- Нэмэлт санхүүжилтийн дансаар НҮБ-ын хүүхдийг ивээх сангаас санхүүжүүлсэн "Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн систем PRIMERO-г нэвтрүүлэх" үйл ажиллагаанд зориулан олгосон санхүүжилтээс 4,340.0 мянган төгрөгийг ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүйн улмаас санхүүжилтийг буцаан татуулсан, жилийн эцсийн аудитаар хэрэгжилтийг үнэлэхэд гүйцэтгэгч компани дутуу хэрэгжүүлсэн ажлыг дуусган санхүүжилтээ авсан;
- Үндсэн хөрөнгийн шинж чанартай 4,917.0 мянган төгрөгийн үнэ бүхий 2 төрлийн сүлжээний свич төхөөрөмжийг бараа материалын дансанд бүртгэснийг залруулж үндсэн хөрөнгөд бүртгэсэн.
- ХГБХХЕГ-ын эзэмшил дэх 2 газрыг байгууллагын хөрөнгөд бүртгээгүй зөрчлийг арилгаж хөрөнгөд бүртгэн, тайлагнасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 25,212.4 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоосныг 14,000.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн актыг барагдуулсан, 723,816.7 мянган төгрөгийн 8 албан шаардлага хүргүүлснээс 665,666.6 мянган төгрөгийн 6 албан шаардлагыг хэрэгжүүлсэн, 1,859,293.5 мянган төгрөгийн 10 зөвлөмж өгснөөс 1,471,198.3 мянган төгрөгийн 8 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна. Аудитын шийдвэрийн хэрэгжилт дунджаар 97.4 хувьтай байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	25,212.4	1	16,000.0	63.4
Албан шаардлага	8	723,816.6	6	665,666.6	91.9
Зөвлөмж	10	1,859,293.5	9	1,859,293.5	100
Нийт дүн	21	2,608,322.5	16	2,540,960.2	97.4

Өмнөх оны аудитаар нь 15 ажилтанд илүү тооцож олгосон 11,212.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг бүрэн төлж барагдуулаагүй, Нийслэлийн мэдээллийн төвтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг бүрэн хангуулаагүй, бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний ажлын даалгаварт тусгагдсан ажлыг бүрэн гүйцэтгээгүй байхад хүлээж авсан 2 албан шаардлагын хэрэгжилт хангагдаагүй, Шилэн дансны тухай хуулийн дагуу цахим хуудсанд мэдээллийг хугацаа хоцруулан мэдээлсэн зөрчил арилаагүй байгаа нь тухайн онд хариуцаж байсан албан хаагчид ажлаас чөлөөлөгдөж, тайлант онд тус зөрчилд хариуцлага тооцох албан хаагчид байхгүй тул тайлант онд шинээр томилогдсон албан хаагчдад зөрчлийг таслан зогсоох 4 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Өмнөх оны аудитаар өгсөн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй байгаа зөрчил арилаагүй, тайланд онд давтан гаргасан тул албан шаардлага хүргүүлсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах горим сорилыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

1. Тайланд онд шинээр худалдаж авсан зарим программ, хангамжийн худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуультай нийцүүлж зохион байгуулсан эсэх;
2. Дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй ирүүлсэн хөрөнгийг харьяа байгууллагад шилжүүлсэн хөрөнгийн хөдөлгөөнийг тулган баталгаажуулах;
3. Татварын цахим системийн авсан тодорхойлолтоор 106,179.4 мянган төгрөгийн авлагатай байгаа нь татварын байгууллагатай эцэслэн тооцоо нийлсэн эсэхийг баталгаажуулсан горим сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 552,121.4 мянган төгрөгийн 6 алдаа¹ илэрсэнд аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.Үүнд:

Залруулсан алдаа:

- ГБХНХС-ын 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/131 дүгээр тушаалаар харьяа байгууллагуудад хуваарилсан 7,498.5 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар хүлээн авсан хөрөнгөөр бүртгэж, тайлагнасан;
- Санхүү байдлын тайланд татаас, санхүүжилтийн авлагыг 48,942.4 мянган төгрөгөөр дутуу, татвар, НДШ-ийн авлагыг 84,874.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Санхүү байдлын тайланд ажиллагчидтай холбогдсон өглөг дансыг 84,874.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Санхүү байдлын тайлангийн тайлант үеийн үр дүн санхүүгийн үр дүнгийн тайлан дахь тайлант үеийн үр дүнгээс 7,482.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Санхүүгийн үр дүнгийн тайлан дахь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого үндсэн хөрөнгийн тодруулгын тайлан дахь үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоос 7,498.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Урьдчилж гарсан зардлыг 310,950.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;

Эдгээр алдаанууд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө.", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасантай тус тус нийцэхгүй, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулгын 1.27, УСНББОУС-17 Үндсэн хөрөнгийн 17.42 дахь параграф болон санхүүгийн аудитын "Оршин байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 2,453,071.0 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд, 4,804.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 2,421,605.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 10 албан шаардлагыг хүргүүлж, 26,660.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2,453,071.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,334,668.7 мянган төгрөгөөр давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. - Тайлант онд 2 албан хаагчид 1,587.7 мянган төгрөгийн жилийн эцсийн үр дүнгийн мөнгөн урамшууллыг тушаал, шийдвэргүй, газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн Б/84 дүгээр тушаалд 1 албан хаагчид хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах ажилтны нэмэгдлийг олгох талаар тусгаагүй байхад 2,708.8 мянган төгрөгийг тус тус олгосон.
- Тайлант онд сахилгын шийтгэлтэй 1 албан хаагчийн цалингийн хэмжээг 3 сарын хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэлтэй байх хугацааны нийт 507.9 мянган төгрөгийг цалинг хасаж тооцоогүй.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчдад илүү олгосон нийт 4,804.4 мянган төгрөгийн цалинг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Монгол Улсад Хүүхдийн байгууллага, хөдөлгөөн үүсэж, хөгжсөний 100 жилийн ой болон хүүхдийн баярын үйл ажиллагаанд зориулж нийт 168,367.0 мянган төгрөгийн материал худалдаж авсныг бараа материалын дансанд бүртгээгүй шууд зардалд зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө.", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах," гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу хөтөлж, бүртгээгүй зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлэв.

2. - Монгол Улсад Хүүхдийн байгууллага, хөдөлгөөн үүсэж, хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан баярын тоглолтын тайз заслын зардалд 37,800.0 мянган төгрөгийг, тоглолтод оролцох урлагийн хүүхдүүдийг байрлуулах, бэлтгэл хангах ажлыг зохион байгуулах зардалд 29,520.0 мянган төгрөгийн нэг төрлийн ижил бараа, ажил үйлчилгээнд төсөвт өртгийг хуваан шууд худалдан авалт хийсэн.

- Асрамж халамжийн төв, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчилгээ авч байгаа зорилтот бүлгийн хүүхдүүдэд шинэ жилээр бэлэг худалдан авах зардалд нийт 81,920.0 мянган төгрөгийг 2 аж ахуйн нэгжээс нэг төрлийн ижил бараа ажил үйлчилгээнд төсөвт өртгийг хуваан шууд худалдан авалт хийсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална." 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 41 дүгээр зүйлийн 41.1-т "Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна", 41.1.1-т "энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралтын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар ангиллын " 1-т "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа 20.0 сая төгрөг, ажил 20.0 сая төгрөг үйлчилгээ 20.0 сая төгрөг" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант онд дотоод томилолтын зардлаас харьяа байгууллагын төсөв захирагч болон тус газрын мэргэжилтний Бүгд Найрамдах Замби Улсад "Олон улсын хүүхдийн тусламжийн утасны 11 дэх удаагийн зөвлөлдөх уулзалт"-д оролцох гадаад томилолтын зардалд 16,501.4 мянган төгрөгийг зарцуулж, зардлын эдийн засгийн ангилал зөрчиж тайлагнасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; Сангийн сайдын 2025 оны 112 дугаар "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай" тушаалын хоёрдугаар Хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар"-ын "Төсвийн захирагчийн үүрэг: зардлыг ангиллын тодорхойлолтод заасны дагуу нийцүүлж зөв бүртгэх, мэдээлэх, тайлагнах үүргийг төсвийн бүх захирагчид хүлээнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зардлын эдийн засгийн ангилал зөрчин зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

4. Хүүхэд, гэр бүлийн хөгжил оролцоог дэмжих үйл ажиллагааны хүрээнд нэг үүсвэрээс худалдан авах ажиллагааны аргыг хэрэглэн нэг хуулийн этгээдтэй нийт 535,275.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Гэр бүлийн виртуал зөвлөх" AR контент үйлчилгээг AR Mongolia аппликейшнаар дамжуулан үйлчилгээ авахаар "Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын үйл ажиллагааг цахим технологийн тусламжтай иргэн бүрт хүртээмжтэй хүргэх" ажлын худалдан авах ажиллагаа болон байгуулсан гэрээ, санхүүжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Сангийн яамны 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 02/10960 дугаар албан бичигт: "... Хүүхэд, гэр бүлийн оролцоог дэмжих үйл ажиллагааны хүрээнд хийгдэх худалдан авалттай холбоотойгоор оюуны өмчийн эрхийг хамгаалах шаардлагаар бараа, ажил, үйлчилгээг үйлдвэрлэгч оюуны өмчийн эрх эзэмшигч гүйцэтгэх боломжтой болох нь нотлогдсон тохиолдолд нэг үүсвэрээс худалдан авах аргыг хэрэглэх боломжтой байна." гэж мэдэгдсэн ч тухайн үйлчилгээг гэрээ байгуулсан хуулийн этгээд үзүүлж чадах боломжтой гэдгийг нотолсон баримт хангалтгүй; (энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг иргэн, хуулийн этгээдийн талаар судалгаа гаргаагүй)
- Уг ажил үйлчилгээг гүйцэтгэгч "Аргун студио" ХХК нь тус газартай хамтран ажиллах хүсэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 27-ний өдрийн 25/134 тоот албан бичгээр хамтран ажиллах хүсэлт ирүүлсний дагуу тус газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/220 дугаар тушаалаар Үнэлгээний хороог байгуулж "Гэр бүлийн виртуал зөвлөх" AR контент үйлчилгээний худалдан авах ажиллагааг 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан;
- "Аргун студио" ХХК-тай 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, 12 дугаар сарын 18-ны өдөр гэрээг дүгнэн хүлээн авч, 12 дугаар сарын 23-ны өдөр санхүүжилтийг бүрэн олгосон боловч захиалагч байгууллагаас шаардлага хангасан мэдээллийг бүрэн гаргаж өгөөгүйгээс шалтгаалан одоог хүртэл үйл ажиллагаанд ашиглаагаагүй. Үүнд: QR бүхий, зурагтай наадаг стикерийг 997,000 ширхгийг гэрээний үнийн дүнгийн 41.9 хувь буюу 224,325.0 мянган төгрөгөөр худалдан авсан, уг стикер нь бүрэн ашиглагдаагүй.
- Ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлд баталгаат хугацаа 36 сар гэсэн мөртлөө барьцааны хөрөнгийн талаар тусгаагүйгээс санхүүжилтийг бүрэн олгосон нь цаашид ашиглалтын явцад уг виртуал AR контент үйлчилгээ нь ажиллахгүй болсон тохиолдолд гарах зардлыг нэмж төсвөөс зарцуулах эрсдэлтэй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах";

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.", 12 дугаар зүйлийн 12.8-д "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолт бэлтгэхэд өрсөлдөөнийг хязгаарлахгүй байх зөвлөгөөг тухайн салбарын иргэний нийгмийн байгууллага, аж ахуй эрхлэгчээс авч болно." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, санхүүжилтийг бүрэн олгосон, хүлээн авсан ажил үйлчилгээ нь бүрэн ашиглагдаагүй зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

5. Анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтын шаардлага хангаагүй нийт 180,971.1 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн нь санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна. Үүнд:

1. Мэдээлэл технологийн зардлаас 6,351.1 мянган төгрөгөөр цахим сайтын хөгжүүлэлт хийлгэхдээ харилцагч байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулаагүй, хийсэн ажлын тайлан байхгүй;
2. Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын өдөрт зориулан 1 хуулийн этгээдэд 1,749.9 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч зардлын анхан шатны баримтгүй;
3. Үндэсний их баяр наадмын үед хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавьж ажиллахад 1 хуулийн этгээдтэй 17,720.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан боловч гэрээнд мөнгөн дүнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй 3,200.0 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн;
4. Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр хувийн хэвшлийн байгууллагын зохион байгуулсан төлбөртэй арга хэмжээнд оролцсон 2 иргэн, 7 хуулийн этгээдтэй гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлж олгосон нийт 169,670.0 мянган төгрөгийн хийсэн ажлын тайланг ирүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай нийцэхгүй байна."

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэж санхүүгийн тайланд тусгасан, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулаагүй зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

6. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 1,228,895.6 мянган төгрөгийн үнэ бүхий 1,094 нэр төрлийн /14,000.0 мянган төгрөгийн өртөгтэй барилга байгууламж, 1,063,597.1 мянган төгрөгийн өртөгтэй машин тоног төхөөрөмж, 34,436.0 мянган төгрөгийн өртөг бүхий тавилга эд хогшил, 116,862.5 мянган төгрөгийн өртөг бүхий программ хангамж/ хөрөнгө санхүүгийн тайланд бүртгэлтэй байна. Үүнээс: Харьяа байгууллагуудад шилжүүлсэн 553,700.0 мянган төгрөгийн өртөгтэй 450 ширхэг таблет, 56,655.0 мянган төгрөгийн өртөгтэй 450 хуруу уншигч, 33,993.0 мянган төгрөгийн өртөгтэй 270 ширхэг хуруу уншигч, 2,433.7 мянган төгрөгийн өртөгтэй график карт, 5,000.0 мянган төгрөгийн төгөлдөр хуур нийт 274 ширхэг үндсэн хөрөнгө, бусад хангамжийн материалд 6,264.0 мянган төгрөгийн 720 ширхэг хөрвүүлэгч, 1,625.0 мянган төгрөгийн 650 ширхэг IC карт хөрөнгөд бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг

баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.", 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна.", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1-д "Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар төрийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.", 7.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж хөрөнгийн дахин үнэлгээ хийлгээгүй, харьяа байгууллагуудад шилжүүлсэн хөрөнгийг данснаас хасаагүй зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

7. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 2013 онд худалдаж авсан 56,379.0 мянган төгрөгийн үнэ бүхий 78.68 м.кв орон сууцны үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг холбогдох байгууллагаар гаргуулан аваагүй, тухайн орон сууцыг үнэ төлбөргүй ашиглуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэргүй, гэрээ байгуулаагүй "Монголын Дауны холбоо" нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагад үнэ төлбөргүй ашиглуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйл 27.1-д "Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг холбогдох байгууллагаар гаргуулан аваагүй, холбогдох байгууллагын шийдвэргүй үнэ төлбөргүй ашиглуулсан зэрэг зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

8. Газрын даргын нэмэгдэл олгох тушаал, шийдвэргүй ажилтнуудад нийт 10,034.5 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3.3-т "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөв захирагчийн тушаал, шийдвэргүй илүү цагийн хөлс олгосон зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

9. Тус байгууллагад 2025 онд 3-4 сарын хугацаанд ажиллаад төрийн албанаас түр чөлөөлөгдсөн 2 албан хаагчид нийт 11,592.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д ““Анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог;”, 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийн удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээн.”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;”, ХГБХХЕГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/33 дугаар тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.10.13-т “Ажилтан хүндээр өвчилсөн, өндөр өртөгтэй хагалгаанд орох үед гурван сарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний буцалтгүй тусламжийг 1 удаа олгоно. “гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад буцалтгүй тусламж олгосон зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

10. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар даалгаврыг зөрчин хэвлэл мэдээллийн хэрэгсэл, телевиз, сайт, өдөр тутмын сонин зэрэг хэвлэл мэдээллийн 13 байгууллагатай 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр гэрээ байгуулан 64,350.0 мянган төгрөгийг 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр зарцуулсан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх;”, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах” 1.4.4-т “гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх мэргэжлийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ шинээр байгуулахгүй байх”, 1.4.5-д “төрийн байгууллагын хэрэгжүүлдэг төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлын санхүүжилтийг дараагийн төсвийн жилд шилжүүлэх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай албан даалгаврыг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Зардлын данстай холбоотой асуудал:

Илрүүлэлт 1: Газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А/114 дүгээр тушаалаар Асрамж халамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг газрын хүүхдүүдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны зардалд 42,280.0 мянган төгрөгийг олгохоор баталж, олон улсын хүүхдийн найрамдал цогцолборт 48 хүүхдийг амраан 23,520.0 мянган төгрөгийг шилжүүлсэн, үүнээс гадна 26,660.9 мянган төгрөгийн андуурч хийсэн гүйлгээ тус байгууллагын дансанд буцаж ороогүй, ОУХНЦ-ын данснаас улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог;”, 14 дүгээр зүйлийн 14.3-т “Нягтлан бодох бүртгэлийн

мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ: 14.3.1. анхан шатны баримт бүрдүүлэх; 14.3.2. журналд бичих; 14.3.3. дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх; 14.3.4. ажил, гүйлгээний мэдээ гаргах; 14.3.5. санхүүгийн тайлан гаргах." гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна

Өгсөн зөвлөмж: Төсвийн зарцуулалт, санхүүгийн гүйлгээний баримтжуулалт болон бүртгэлийн үйл явцыг, үнэн зөвөөр зохион байгуулж, санхүүжилтийн олголтыг бодит гүйцэтгэл, нотлох баримтаар бүрэн баталгаажуулж санхүү, бүртгэлийн сахилга хариуцлагыг сайжруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
ГБХНХС-ын 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/131 дүгээр тушаалаар харьяа байгууллагуудад хуваарилсан 7,498.5 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар хүлээн авсан хөрөнгөөр бүртгэж, тайлагнасан.	1	7,498.5	-	-	1	7,498.5	1	7,498.5	-	-	-	-
Санхүү байдлын тайланд татаас, санхүүжилтийн авлагыг 48,942.4 мянган төгрөгөөр дутуу, татвар, НДШ-ийн авлагыг 84,874.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан	1	133,817.1	-	-	1	133,817.1	1	133,817.1	-	-	-	-
Санхүү байдлын тайланд ажиллагчидтай холбогдсон өглөг дансыг 84,874.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	1	84,874.7	-	-	1	84,874.7	1	824,076.5	-	-	-	-
Санхүү байдлын тайлангийн тайлант үеийн үр дүн санхүүгийн үр дүнгийн тайлан дахь тайлант үеийн үр дүнгээс 7,482.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	7,482.4	-	-	1	7,482.4	1	7,482.4	-	-	-	-
Санхүүгийн үр дүнгийн тайлан дахь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого үндсэн хөрөнгийн тодруулгын тайлан дахь үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоос 7,498.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	7,498.5	-	-	1	7,498.5	1	7,498.5	-	-	-	-
Санхүү байдлын тайланд урьдчилж гарсан зардлыг 310,950.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	310,950.0	-	-	1	310,950.0	1	310,950.0	-	-	-	-
Дүн	6	552,121.4	-	-	6	552,121.4	6	552,121.4	-	-	-	-

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1. Тайлант онд 2 албан хаагчид 1,587.7 мянган төгрөгийн жилийн эцсийн үр дүнгийн мөнгөн урамшууллыг тушаал, шийдвэргүй, газрын даргын 2025 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн Б/84 дүгээр тушаалд 1 албан хаагчид хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах ажилтны нэмэгдлийг олгох талаар тусгаагүй байхад 2,708.8 мянган төгрөгийг тус тус олгосон. 2. Тайлант онд сахилгын шийтгэлтэй 1 албан хаагчийн цалингаас сахилгын шийтгэлтэй байх хугацааны 507.9 мянган төгрөгийг хасаж тооцоогүй.	1	4,804.4	1	4,804.4	-	-	-	-	-	-
Монгол Улсад Хүүхдийн байгууллага, хөдөлгөөн үүсэж, хөгжсөний 100 жилийн ой болон Хүүхдийн баярын үйл ажиллагаанд зориулж худалдан авсан 168,367.0 мянган төгрөгийн материалыг бараа материалын дансаар дамжуулж бүртгээгүй шууд зардлаар тайлагнасан	1	168,367.0	-	-	1	168,367.0	-	-	-	-
Монгол Улсад Хүүхдийн байгууллага, хөдөлгөөн үүсэж, хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан баярын тоглолтын тайз заслын зардалд 37,800.0 мянган төгрөгийг, тоглолтод оролцох урлагийн хүүхдүүдийг байрлуулах, бэлтгэл хангах ажлыг зохион байгуулах зардалд 29,520.0 мянган төгрөгийн нэг төрлийн ижил бараа, ажил үйлчилгээнд төсөвт өртгийг хуваан шууд худалдан авалт хийсэн. Асрамж халамжийн төв, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчилгээ авч байгаа зорилтот бүлгийн хүүхдүүдэд шинэ жилээр бэлэг худалдан авах зардалд нийт 81,920.0 мянган төгрөгийг 2 аж ахуйн нэгжээс нэг төрлийн ижил бараа ажил үйлчилгээнд төсөвт өртгийг хуваан шууд худалдан авалт хийсэн.	1	149,240.0	-	-	1	149,240.0	-	-	-	-
Тайлант онд дотоод томилолтын зардлаас харьяа байгууллагын төсөв захирагч болон тус газрын мэргэжилтний Бүгд Найрамдах Замби Улсад "Олон улсын хүүхдийн тусламжийн утасны 11 дэх удаагийн зөвлөлдөх	1	16,501.4	-	-	1	16,501.4	-	-	-	-

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

уулзалт"-д оролцох гадаад томилолтын зардалд 16,501.4 мянган төгрөгийг зарцуулж, эдийн засгийн ангилал зөрчиж тайлагнасан байна										
Хүүхэд, гэр бүлийн хөгжил оролцоог дэмжих үйл ажиллагааны хүрээнд нэг үүсвэрээс худалдан авах ажиллагааны аргыг хэрэглэн нэг хуулийн этгээдтэй нийт 535,275.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Гэр бүлийн виртуал зөвлөх" AR контент үйлчилгээг AR Mongolia аппликейшнаар дамжуулан үйлчилгээ авахаар "Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын үйл ажиллагааг цахим технологийн тусламжтай иргэн бүрт хүртээмжтэй хүргэх" ажлын худалдан авах ажиллагаа болон байгуулсан гэрээ, санхүүжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд: Сангийн яамны 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 02/10960 дугаар албан бичигт: "... Хүүхэд, гэр бүлийн оролцоог дэмжих үйл ажиллагааны хүрээнд хийгдэх худалдан авалттай холбоотойгоор оюуны өмчийн эрхийг хамгаалах шаардлагаар бараа, ажил, үйлчилгээг үйлдвэрлэгч оюуны өмчийн эрх эзэмшигч гүйцэтгэх боломжтой болох нь нотлогдсон тохиолдолд нэг үүсвэрээс худалдан авах аргыг хэрэглэх боломжтой байна." гэж мэдэгдсэн ч тухайн үйлчилгээг гэрээ байгуулсан хуулийн этгээд үзүүлж чадах боломжтой гэдгийг нотолсон баримт хангалтгүй; (энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг иргэн, хуулийн этгээдийн талаар судалгаа гаргаагүй) Уг ажил үйлчилгээг гүйцэтгэгч "Аргун студио" ХХК нь тус газартай хамтран ажиллах хүсэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 27-ний өдрийн 25/134 тоот албан бичгээр хамтран ажиллах хүсэлтийн ирүүлсний дагуу тус газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/220 тоот тушаалаар Үнэлгээний хороог байгуулж "Гэр бүлийн виртуал зөвлөх" AR контент үйлчилгээний худалдан авах ажиллагааг 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан. "Аргун студио" ХХК-тай 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, 12 дугаар сарын 18-ны өдөр гэрээг дүгнэн хүлээн авч, 12 дугаар сарын 23-ны өдөр санхүүжилтийг бүрэн олгосон боловч захиалагч байгууллагаас шаардлага хангасан мэдээллийг бүрэн гаргаж өгөөгүйгээс одоо хүртэл үйл ажиллагаанд ашиглааагүй. Үүнд: QR бүхий, зурагтай наадаг стикерийг 997,000 ширхэгийг гэрээний үнийн дүнгийн 41.9 хувь буюу	1	535,275.0	-	-	1	535,275.0	-	-	-	-

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

224,325.0 мянган төгрөгөөр худалдан авсан, уг стикер нь бүрэн ашиглагдаагүй.										
Ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлд баталгаат хугацаа 36 сар гэсэн мөртлөө барьцааны хөрөнгийн талаар тусгаагүйгээс санхүүжилтийг бүрэн олгосон нь цаашид ашиглалтын явцад уг виртуал AR контент үйлчилгээ нь ажиллахгүй болсон тохиолдолд гарах зардлыг нэмж төсвөөс зарцуулах эрсдэлтэй.										
Анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтын шаардлага хангаагүй нийт 180,971.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн нь санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна. Үүнд: 1. Мэдээлэл технологийн зардлаас 6,351.1 мянган төгрөгөөр цахим сайтын хөгжүүлэлт хийлгэхдээ харилцагч байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулаагүй, хийсэн ажлын тайлан байхгүй; 2. Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын өдөрт зориулан 1 хуулийн этгээдэд 1,749.9 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч зардлын анхан шатны баримтгүй. 3. Үндэсний их баяр наадмын үед хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавьж ажиллахад 1 хуулийн этгээдтэй 17,720.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан боловч гэрээнд мөнгөн дүнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй 3,200.0 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн; 4. Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр хувийн хэвшлийн байгууллагын зохион байгуулсан төлбөртэй арга хэмжээнд оролцсон 2 иргэн, 7 хуулийн этгээдтэй гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлж олгосон нийт 169,670.0 мянган төгрөгийн хийсэн ажлын тайланг ирүүлээгүй.	1	180,971.0	-	-	1	180,971.0	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 14,000.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 1,063,597.1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 34,436.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 116,862.5 мянган төгрөгийн программ хангамж нийт 1,228,895.6 мянган төгрөгийн үнэ бүхий 1,094 нэр төрлийн хөрөнгө санхүүгийн тайланд бүртгэлтэй байна. Үүнээс: Харьга байгууллагуудад шилжүүлсэн 553,700.0 мянган төгрөгийн өртөгтэй 450 ширхэг таблет, 56,655.0 мянган төгрөгийн өртөгтэй 450 хуруу уншигч, 33,993.0 мянган төгрөгийн өртөгтэй 270 ширхэг хуруу уншигч, 2,433.7 мянган төгрөгийн өртөгтэй график карт, 5,000.0 мянган төгрөгийн төгөлдөр хуур 274 ширхэг үндсэн хөрөнгө, бусад хангамжийн материалд 6,264.0 мянган төгрөгийн 720	1	1,228,895.6	-	-	1	1,228,895.6	-	-	-	-

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ширхэг хөрвүүлэгч, 1,625.0 мянган төгрөгийн 650 ширхэг IC карт хөрөнгөд бүртгэлтэй байна.										
Газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А/114 дүгээр тушаалаар Асрамж халамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг газрын хүүхдүүдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны зардалд 42,280.0 мянган төгрөгийг олгохоор баталж, олон улсын хүүхдийн найрамдал цогцолборт 48 хүүхдийг амраан 23,520.0 мянган төгрөгийг шилжүүлсэн, үүнээс гадна 26,660.9 мянган төгрөгийн андуурч хийсэн гүйлгээг тус байгууллагын дансанд буцааж хийлгүй, ОУХНЦ-ын данснаас улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.	1	26,660.9	-	-	-	-	1	26,660.9	-	-
Тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2013 онд худалдан авсан 78.68 м.кв орон сууцны үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг холбогдох байгууллагаар гаргуулан аваагүй, тухайн орон сууцыг үнэ төлбөргүй ашиглуулах холбогдох байгууллагын шийдвэргүй, гэрээ байгуулаагүй “Монголын Дауны холбоо” НҮТББ-д үнэ төлбөргүй ашиглуулсан.	1	56,379.0	-	-	1	56,379.0	-	-	-	-
Газрын даргын нэмэгдэл хөлс олгох тушаал шийдвэргүй 10,034.5 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг олгосон.	1	10,034.5		-	1	10,034.5	-	-	-	-
Тус байгууллагад 2025 онд 3-4 сарын хугацаанд ажиллаад Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн 2 албан хаагчид нийт 11,592.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг олгосон нь холбогдох хууль, тогтоомжтой нийцэхгүй байна	1	11,592.0	-	-	1	11,592.0	-	-	-	-
Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар даалгаврыг зөрчин хэвлэл мэдээллийн хэрэгсэл, телевиз, сайт, өдөр тутмын сонин зэрэг хэвлэл мэдээллийн 13 байгууллагатай 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр гэрээ байгуулан 64,350.0 мянган төгрөгийг 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр зарцуулсан.	1	64,350.0	-	-	1	64,350.0	-	-	-	-
Дүн	12	2,453,071.0	1	4,804.4	10	2,421,605.7	1	26,660.9	-	-

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Шилэн дансны тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>								
Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2,031,758.1 мянган төгрөгийн 14 гүйлгээ, зарлагын 3,081,748.4 мянган төгрөгийн 110 гүйлгээг мэдээлээгүй, 3,246,491.6 мянган төгрөгийн орлогын 16 гүйлгээг хугацаа хоцроож, 2,307,167.4 мянган төгрөгийн зарлагын 198 гүйлгээг хугацаа хоцроож, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой нийт 81 шийдвэрийг мэдээллийг байршуулаагүй, 27 шийдвэрийг хугацаа хоцруулж байршуулсан байна.	1	10,667,165.7	-	-	1	10,667,165.7	-	-
Дүн	1	10,667,165.7	-	-	1	10,667,165.7	-	-
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>								
Байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэхдээ санхүүгийн тайлан бэлтгэх шаардлагыг хангаагүй, мэргэжлийн бус эрх зүйч мэргэжилтэй албан хаагчид хариуцуулсан байна.	1	-	-	-	-	-	1	-
Байгууллагын хүний нөөц тогтворгүй, тайлант онд нийт 51 албан хаагчаас 6 албан хаагч өөр байгууллагад шилжсэн, 21 албан хаагч ажлаас чөлөөлөгдсөн нь аудитын явцад илэрч буй алдаа зөрчилд тайлбар болон шаардлагатай тайлан гаргуулах, баримт материалтай бүрэн танилцахад хүндрэл учруулж байна. Нийслэлийн ХГБХХГ татан буулгасантай холбоотой чөлөөлөгдсөн албан хаагчдаас 9 албан хаагч шүүхийн байгууллагад хандсан байгаа нь төрд учрах хохирлын хэмжээ, байгууллагын өглөг, авлага нэмэгдэх эрсдэлийг бий болгож байна.	1	-	-	-	-	-	1	-
Байгууллагын санхүүгийн харилцах дансны гүйлгээг зардлын баримттай тулган баталгаажуулахад баримт материал эмх цэгцгүй, зардлын нотлох баримтыг бүрэн бүрдүүлж хавсаргаагүй, тушаал, шийдвэрийн хуулбар хувийг хавсаргасан, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой зардал гаргах зарим тушаалын хавсралт дахь мөнгөн дүнгийн нийлбэр алдаатай нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын хавсралт маягтуудын дагуу архивын хадгаламжийн нэгжийг бүрдүүлээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тус байгууллагын 2018 онд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомжтой нийцээгүй, шинэчлэн баталж мөрдөх ажил хийгдээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй СБД-ийн 8 дугаар хорооны Н-1-0087, 12 тоот хаягт байрлах 1460800074 нэгж талбарын дугаартай 5,472.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 57 м.кв газрын газрын эзэмших эрхийн хугацаа дууссан бөгөөд гэрчилгээ нь хүчин төгөлдөр бус байна.	1	5,472.0	-	-	-	-	1	5,472.0
Өмнөх оны аудитаар “Хурдан морь уралдаанч хүүхдийн бүртгэлийн систем хөгжүүлэх” ажлыг 19,250.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлэхээр “Эйблсофт” ХХК-тай, мөн “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авч буй хүүхдүүдийн бүртгэлийн систем хөгжүүлэх ажлын даалгавар боловсруулах, зөвлөх үйлчилгээ авах” ажлыг 19,400.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлэхээр “Дийг Ай Ти” ХХК-тай тус тус гэрээ байгуулсан боловч систем хөгжүүлэгчийг сонгон шалгаруулаагүйгээс ажлын даалгаварт заасан систем хөгжүүлэх, нэвтрүүлэх явцад хяналт тавих, хөгжүүлэгчээс гүйцэтгэлийг хүлээн авах, захиалагчдад хүлээлгэн өгөх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэлгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон зөрчлийг арилгах талаар өгсөн албан шаардлагыг тус байгууллага бүрэн хэрэгжүүлээгүй байна.	1	38,650.0	-	-	1	38,650.0	-	-
Өмнөх оны аудитаар “Гэртээ эрт харья” аяныг зохион байгуулахаар Нийслэлийн мэдээллийн төвтэй 19,500.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан урьдчилгаа санхүүжилт 13,650.0 мянган төгрөгийг олгосон боловч гэрээний хугацаа дууссан, хэрэгжилтийг бүрэн хангуулаагүй” албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.	1	19,500.0	-	-	1	19,500.0	-	-
Төрийн аудитын байгууллагад 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэг "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна"-т заасны дагуу иж бүрэн ирүүлээгүй.	1	-					1	-
Өмнөх оны аудитаар өгөгдсөн нэр бүхий 15 ажилтанд нийт 11,212.3 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон төлбөрийн актыг төлж барагдуулаагүй.	1	11,212.4	-	-	1	11,212.4	-	-
Дүн	9	74,834.4	-	-	3	69,362.4	6	5,472.0
НИЙТ ДҮН	10	10,742,000.1	-	-	4	10,736,528.1	6	5,472.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 78/А017125А

Улаанбаатар хот

САГ-2026/286/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тайлант онд 2 албан хаагчид 1,587,700.00 (нэг сая таван зуун наян долоон мянга долоон зуун) төгрөгийн жилийн эцсийн үр дүнгийн мөнгөн урамшууллыг тушаал, шийдвэргүй, газрын даргын 2025 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн Б/84 дугаар тушаалд 1 албан хаагчид хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах ажилтны нэмэгдлийг олгох талаар тусгаагүй байхад 2,708,800.00 (хоёр сая долоон зуун найман мянга найман зуун) төгрөгийг тус тус олгосон.

2. Тайлант онд сахилгын шийтгэлтэй 1 албан хаагчийн сахилгын шийтгэлтэй байх хугацааны 507,900.00 (таван зуун долоон мянга есөн зуун) төгрөгийн цалинг хасаж тооцоогүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох";, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Албан хаагчдад илүү олгосон нийт 4,804,400.00 (дөрвөн сая найман зуун дөрвөн мянга дөрвөн зуун) төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Баярсайхан/, Захиргаа, удирдлагын газрын дарга /Б.Доржхуяг/, Ерөнхий ахлах нягтлан бодогч /Н.Батбаяр/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Г.ӨСӨХЖАРГАЛ
Д.НОМИНГУА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг: 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Akr\2026\0225 SAG-49.Docx

1526160540



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 395/А0171254

Улаанбаатар хот

САГ-2026/286/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсад Хүүхдийн байгууллага, хөдөлгөөн үүсэж, хөгжсөний 100 жилийн ой болон хүүхдийн баярын үйл ажиллагаанд зориулж нийт 168,367,000.00 (нэг зуун жаран найман сая гурван зуун жаран долоон мянган) төгрөгийн материал худалдаж авсныг бараа материалын дансанд бүртгээгүй шууд зардалд зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө.", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах," гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу хөтөлж, бүртгээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Баярсайхан/, Захиргаа, удирдлагын газрын дарга /Б.Доржхуяг/, Дотоод аудит, хяналт шалгалт хариуцсан ахлах мэргэжилтэн /Ц.Өлзийдүүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Г.ӨСӨХЖАРГАЛ
Д.НОМИНГУА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-62.Docx

1526180764



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 396/АД171254

Улаанбаатар хот

САГ - 2026/286/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Монгол Улсад Хүүхдийн байгууллага, хөдөлгөөн үүсэж, хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан баярын тоглолтын тайз заслын зардалд 37,800,000.00 (гучин долоон сая найман зуун мянган) төгрөгийг, тоглолтод оролцох урлагийн хүүхдүүдийг байрлуулах, бэлтгэл хангах ажлыг зохион байгуулах зардалд 29,520,000.00 (хорин есөн сая таван зуун хорин мянган) төгрөгийн нэг төрлийн ижил бараа, ажил үйлчилгээнд төсөвт өртгийг хуваан шууд худалдан авалт хийсэн.

2. Асрамж халамжийн төв, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчилгээ авч байгаа зорилтот бүлгийн хүүхдүүдэд шинэ жилээр бэлэг худалдан авах зардалд нийт 81,920,000.00 (наян нэгэн сая есөн зуун хорин мянган) төгрөгийг 2 аж ахуйн нэгжээс нэг төрлийн ижил бараа ажил үйлчилгээнд төсөвт өртгийг хуваан шууд худалдан авалт хийсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална." 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 41 дүгээр зүйлийн 41.1-т "Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна", 41.1.1-т "энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралтын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар ангиллын " 1-т "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа 20 сая.төгрөг, ажил 20.сая төгрөг үйлчилгээ 20 сая.төгрөг" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "төрийн болон орон нутгийн өмч

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230


Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-62.Docx

1526180766

хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол,” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Баярсайхан/, Захиргаа, удирдлагын газрын дарга /Б.Доржхуяг/, Дотоод аудит, хяналт шалгалт хариуцсан ахлах мэргэжилтэн /Ц.Өлзийдүүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Г.ӨСӨХЖАРГАЛ
Д.НОМИНГУА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 397/А0171254

Улаанбаатар хот

САГ - 2026/286/НА-СТА - ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд дотоод албан томилолтын зардлаас харьяа байгууллагын төсөв захирагч болон тус газрын мэргэжилтний Бүгд Найрамдах Замби Улсад "Олон улсын хүүхдийн тусламжийн утасны 11 дэх удаагийн зөвлөлдөх уулзалт"-д оролцох гадаад томилолтын зардалд 16,501,400.00 (арван зургаан сая таван зуун нэгэн мянга дөрвөн зуун) төгрөгийг зарцуулж, эдийн засгийн ангилал зөрчиж тайлагнасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2025 оны 112 дугаар "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай" тушаалын хоёрдугаар Хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар" -ын "Төсвийн захирагчийн үүрэг: зардлыг ангиллын тодорхойлолтод заасны дагуу нийцүүлж зөв бүртгэх, мэдээлэх, тайлагнах үүргийг төсвийн бүх захирагчид хүлээнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зардлын эдийн засгийн ангилал зөрчин зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Баярсайхан/, Захиргаа, удирдлагын газрын дарга /Б.Доржхуяг/, Дотоод аудит, хяналт шалгалт хариуцсан ахлах мэргэжилтэн /Ц.Өлзийдүүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Г.ӨСӨХЖАРГАЛ
Д.НОМИНГУА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-26 230

Z:\Alban Shaardlaga\20260125 SAG-62.Docx

1526180768



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 398/А0171254

Улаанбаатар хот

САГ-2026/286/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүүхэд, гэр бүлийн хөгжил оролцоог дэмжих үйл ажиллагааны хүрээнд нэг үүсвэрээс худалдан авах ажиллагааны аргыг хэрэглэн нэг хуулийн этгээдтэй нийт 535,275,000.00 (таван зуун гучин таван сая хоёр зуун далан таван мянган) төгрөгийн төсөвт өртөгтэй "Гэр бүлийн виртуал зөвлөх" AR контент үйлчилгээг AR Mongolia аппликейшнаар дамжуулан үйлчилгээ авахаар "Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын үйл ажиллагааг цахим технологийн тусламжтай иргэн бүрт хүртээмжтэй хүргэх" ажлын худалдан авах ажиллагаа болон байгуулсан гэрээ, санхүүжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Сангийн яамны 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 02/10960 дугаар албан бичигт: "... Хүүхэд, гэр бүлийн оролцоог дэмжих үйл ажиллагааны хүрээнд хийгдэх худалдан авалттай холбоотойгоор оюуны өмчийн эрхийг хамгаалах шаардлагаар бараа, ажил, үйлчилгээг үйлдвэрлэгч оюуны өмчийн эрх эзэмшигч гүйцэтгэх боломжтой болох нь нотлогдсон тохиолдолд нэг үүсвэрээс худалдан авах аргыг хэрэглэх боломжтой байна." гэж мэдэгдсэн ч тухайн үйлчилгээг гэрээ байгуулсан хуулийн этгээд үзүүлж чадах боломжтой гэдгийг нотолсон баримт хангалтгүй; (энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг иргэн, хуулийн этгээдийн талаар судалгаа гаргаагүй)
- Уг ажил үйлчилгээг гүйцэтэгч "Аргун студио" ХХК нь тус газартай хамтран ажиллах хүсэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 27-ний өдрийн 25/134 тоот албан бичгээр хамтран ажиллах хүсэлтийн ирүүлсний дагуу тус газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/220 тоот тушаалаар Үнэлгээний хороог байгуулж "Гэр бүлийн виртуал зөвлөх" AR контент үйлчилгээний худалдан авах ажиллагааг 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан.
